



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2014 оны 11 сарын 12 өдөр

Дугаар 404

Улаанбаатар хот


Дэд зөвлөлийн бүрэлдэхүүн,  
ажиллах журам батлах тухай

Монгол улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, Хүний дархлал хомсдлын вирусын халдвар, дархлалын олдмол хомсдлоос сэргийлэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, Улсын их хурлын 2001 оны 81, Засгийн газрын 2013 оны 425 дугаар тогтоолуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн үндэсний зөвлөлийн дэргэдэх Нийгмийн эрүүл мэндийн дэд Зөвлөлийн ажиллах журмыг нэгдүгээр, дэд Зөвлөлийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралт ёсоор баталсугай.

2. Нийгмийн эрүүл мэндийн дэд зөвлөлийн үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангаж ажиллахыг Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Я.Буянжаргал/-т үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавихыг Төрийн нарийн бичгийн дарга /А.Эрдэнэтуяа/-д даалгасугай.

САЙД  Н.УДВАЛ

## ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ДЭРГЭДЭХ НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ДЭД ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Эрүүл мэндийн үндэсний зөвлөлийн Нийгмийн эрүүл мэндийн дэд зөвлөл нь (цаашид “дэд зөвлөл” гэнэ) нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг зохион байгуулахад салбар хоорондын хамтын ажиллагааг уялдуулан, нэгдсэн зохицуулалтаар хангах ерөнхий чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөлдөх байгууллага мөн.

1.2. Дэд зөвлөл нь үйл ажиллагаандаа Эрүүл мэндийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомж, Нийгмийн эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлогын баримт бичиг, энэхүү журмыг баримтлан Эрүүл мэндийн үндэсний зөвлөлийн удирдлагад ажиллана.

1.3. Дэд зөвлөл нь тогтоосон журмын дагуу үйлдсэн тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

### Хоёр. Дэд зөвлөлийн чиг үүрэг

2.1. Дэд зөвлөл нь дараах чиг үүргүүдийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- 2.1.1. Олон салбарын оролцоо шаардсан нийгмийн эрүүл мэндийн арга хэмжээний хэрэгжилтийг нэгдсэн удирдлагаар хангах;
- 2.1.2. Нийгмийн эрүүл мэндийн аливаа үйл ажиллагааг бусад салбарын бодлого, чиглэлтэй нийцүүлэх;
- 2.1.3. Хандивлагч болон хамтрагч талуудын үйл ажиллагаа, хувь нэмрийг уялдуулан зохицуулах;
- 2.1.4. Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг зохион байгуулахад нэмэлт нөөцийг бүрдүүлэх, дайчлах;
- 2.1.5. Нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр ажилладаг салбар хоорондын зөвлөлүүдийн үйл ажиллагаанд хяналт тавих, шаардлагатай тохиолдолд үүрэг, чиглэл өгөх;
- 2.1.6. Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал үүссэн үед Эрүүл мэндийн яамны дэргэдэх Шуурхай удирдлагын төвтэй хамтран ажиллах, салбар хоорондын үйл ажиллагааг уялдуулан, зохицуулах;
- 2.1.7. Хүний дархлал хомсдлын вирус (ХДХВ) болон дархлалын олдмол хомсдол (ДОХ)-оос сэргийлэх үйл ажиллагааг үндэсний хэмжээнд уялдуулан зохицуулж, хамтын ажиллагаа, хүчин чармайлтыг чиглүүлэх.

### **Гурав. Дэд зөвлөлийн үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалт**

- 3.1. Дэд зөвлөлийн бүрэлдэхүүнийг Эрүүл мэндийн сайд батална.
- 3.2. Дэд зөвлөл нь дарга, дэд дарга, гишүүд, нарийн бичгийн дарга ба ажлын албанаас бүрдэнэ.
- 3.3. Эрүүл мэндийн яамын Нийгмийн эрүүл мэндийн хэлтэс нь Дэд зөвлөлийн ажлын албаны үүргийг гүйцэтгэнэ.
- 3.4. Дэд зөвлөл нь хамтын удирдлагын байгууллага бөгөөд үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хурал мөн.
- 3.5. Дэд зөвлөл нь хагас жил тутамд хуралдах ба Дэд зөвлөлийн даргын буюу гишүүдийн олонхийн саналаар ээлжит бус хурлыг зарлан хуралдуулж болно.
- 3.6. Дэд зөвлөл нь хуралдаж хэлэлцсэн асуудлаараа шийдвэр гаргах ба тогтоолд Дэд зөвлөлийн дарга гарын үсэг зурж баталгаажуулах ба шаардлагатай тохиолдолд Эрүүл мэндийн үндэсний зөвлөлд асуудал оруулж, шийдвэрлүүлнэ .
- 3.7. Дэд зөвлөлийн хурал гишүүдийн ердийн олонх ирснээр хүчин төгөлдөрт тооцогдох ба шийдвэрийг гишүүдийн ердийн олонхийн саналаар батална.
- 3.8. Дэд зөвлөлийн нарийн бичгийн дарга нь хуралд таслах эрхтэй оролцоно.
- 3.9. Шаардлагатай тохиолдолд хэлэлцэх асуудлын онцлогоос хамааран тухайн чиглэлийн тэргүүлэх мэргэжилтнүүдийг ажиглагчаар урьж оролцуулан, санал зөвлөмжийг сонсно.
- 3.10. Ажиглагч хуралд таслах эрхгүй оролцоно.
- 3.11. Дэд зөвлөлийн үйл ажиллагааг Эрүүл мэндийн яамны жил бүрийн төсөв, Эрүүл мэндийг дэмжих сангийн төсвөөс санхүүжүүлнэ.

### **Дөрөв. Дэд зөвлөлийн эрх, үүрэг**

- 1.1. Нийгмийн эрүүл мэндийн үндэсний хөтөлбөр, стратегид заасан олон салбарын оролцоотойгоор хэрэгжүүлэх үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөөг ажил бүр хэлэлцэж, батлах;
- 1.2. Нэгдсэн төлөвлөгөөнд багтсан үйл ажиллагааг холбогдох яамдын жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган, хэрэгжилтийг хангах;
- 1.3. Дараах асуудлыг хэлэлцэж санал, дүгнэлт, зөвлөмж гаргах:
  - 1.3.1. Салбарын сайдуудын хамтарсан тушаалаар батлах шаардлагатай бодлогын баримт бичиг, дүрэм, журам, зааврын төсөл;
  - 1.3.2. Тухайн жилд хэрэгжиж дуусч буй нийгмийн эрүүл мэндийн үндэсний хөтөлбөр, стратегийн эцсийн тайлан;
  - 1.3.3. Шинээр боловсруулж буй үндэсний хөтөлбөр, стратегийн төсөл;
  - 1.3.4. Дэд зөвлөлийн бүрэлдэхүүнд төлөөлөл багтсан яамд, агентлагаас боловсруулан, Улсын их хурал, Засгийн газарт өргөн барьж буй нийгмийн эрүүл мэндийн ач холбогдол бүхий хууль, бодлогын бусад баримт бичгийн төсөл;
  - 1.3.5. Эрүүл мэндийн үндэсний зөвлөлөөр хэлэлцүүлэх асуудлууд;

1.3.6. Олон салбарын оролцоо шаардлагатай нийгмийн эрүүл мэндийн тулгамдсан асуудлууд.

1.4. Нийгмийн эрүүл мэндийн тулгамдсан асуудлаар олон салбарын төлөөлөл бүхий техникийн ажлын хэсэг томилох;

1.5. Нийгмийн эрүүл мэндийн асуудлыг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сурталчлах, ухуулан таниулах үйл ажиллагаанд оролцох;

1.6. ХДХВ/ДОХ-оос сэргийлэх тухай Монгол улсын хууль, холбогдох хөтөлбөрүүд болон ХДХВ/ДОХ-оос сэргийлэх үндэсний стратегийг хэрэгжүүлэх ажилд холбогдох байгууллагуудыг хүлээсэн үүргийн дагуу татан оролцуулах;

1.7. ХДХВ/ДОХ-ын тархалтын нөхцөл байдлын талаар хэлэлцэж, Улсын их хурал, Засгийн газар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд хүргүүлэх, танилцуулах;

1.8. Дэд зөвлөлийн нэгдсэн төлөвлөгөөнд тусгагдсан үйл ажиллгааны хэрэгжилтийг хагас жил тутам Эрүүл мэндийн үндэсний зөвлөлд тайлагнана.

#### **Тав. Дэд зөвлөлийн даргын эрх, үүрэг**

5.1. Дэд зөвлөлийн дарга дараах эрх, үүргийг хүлээнэ. Үүнд:

5.1.1. Дэд зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах;

5.1.2. Дэд зөвлөлийн ажлын алба, гишүүдэд дэд зөвлөлийн чиг үүргийн хүрээнд үүрэг даалгавар өгөх, биелэлтийг хянах;

5.1.3. Дэд зөвлөлийн хурлыг товлох, хэлэлцэх асуудлын жагсаалт, хурлын шийдвэрийг батлах;

5.1.4. Дэд зөвлөлийн үйл ажиллагааны төсвийн зориулалтыг батлан, хяналт тавих.

#### **Зургаа. Дэд зөвлөлийн нарийн бичгийн даргын эрх, үүрэг**

6.1. Дэд зөвлөлийн нарийн бичгийн дарга Дэд зөвлөлийн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар ажлын албыг өдөр тутмын удирдлагаар ханган ажиллаж, дараах үйл ажиллагааг зохион байгуулна.

6.1.1. Дэд зөвлөлийн хурлаар хэлэлцэх асуудлыг боловсруулах;

6.1.2. Хурлын бэлтгэлийг хангах;


6.1.3. Дэд зөвлөлийн хурлын тэмдэглэл хөтлөх, шийдвэрийг албажуулах;

6.1.4. Дэд зөвлөлийн бичиг хэргийг хөтлөх, архив бүрдүүлэх.

87  
Эрүүл мэндийн сайдын 2014 оны  
11 сарын 12 өдрийн 404 дугаар  
тушаалын 2 дугаар хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ДЭРГЭДЭХ  
НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ДЭД ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга	Эрүүл мэндийн дэд сайд
Орлогч дарга	Эрүүл мэндийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга
Нарийн бичгийн дарга	Эрүүл мэндийн яамны Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн дарга
Гишүүд	Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ажлын албаны дарга; Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дотоод аудитын газрын референт; Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга; Хууль зүйн яамны Эрхзүйн шинэчлэлийн бодлогын газрын дарга; Байгаль орчин ногоон хөгжлийн яамны Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн газрын дарга; Боловсрол, шинжлэх ухааны яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга; Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамны Хүн амын хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга; Соёл, спорт, аялал жуулчлалын яамны Биеийн тамир, спортын бодлогын хэрэгжилтийн газрын дарга; Барилга хот байгуулалтын яамны Стратегийн бодлого төлөвлөлтийн газрын дарга; Онцгой байдлын ерөнхий газрын дэд дарга; Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын дэд дарга;



Цагдаагийн ерөнхий газрын дэд дарга;  
Мал эмнэлэг, үржлийн газрын дэд дарга;  
Хөдөлмөрийн эрүүл мэндийн судлалын төвийн дарга;  
Хүүхдийн төлөө үндэсний газрын дэд дарга;  
Нийслэлийн Засаг даргын Нийгмийн хөгжлийн асуудал  
хариуцсан орлогч дарга  
Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн дарга;  
Халдварт өвчин судлалын үндэсний төвийн захирал;  
Анагаахын шинжлэх ухааны их сургуулийн Нийгмийн  
эрүүл мэндийн сургуулийн захирал;  
Хүний хөгжил, НҮЭМ/Эрх төрийн бус байгууллагуудын  
сүлжээний Ерөнхий зохицуулагч (зөвшилцсөнөөр).